

**Хэрхэн биржийн байнгын
бус гишүүн болох вэ?
Гарын авлага**

Хөдөө аж ахуйн бирж

Монгол улсын “Улсын Их Хурал”-аас “ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг батлан гаргаж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэгдсэн зах зээлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК үүсгэн байгуулагдсан бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн эрхэм зорилго нь “Монголын хөдөө аж ахуйн салбарыг бодит үнэ ханш, оновчтой тогтолцоо бүхий салбар болгон төлөвшүүлэх”-д оршино.

Энэхүү эрхэм зорилгынхоо хүрээнд спот зах зээлийг өргөжүүлэх, биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэх, тэдгээрт суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгслийн туршилтын арилжааг эхлүүлэх, биржийн цахим арилжааны цогц системийг суурилуулах, зах

зээлийн нийт оролцогчдыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

2013 онд биржийн арилжааны дүн 403.6 тэрбум төгрөг байсан бол 2014 онд 554.1 тэрбум төгрөг болоод байна.




График 1. Өдрийн дундаж арилжааны дүн, тэрбум төг




График 1. Биржийн арилжааны дүн 2013 - 2014, сараар




График 3. Биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн хэмжээ – 2014, тн

Агуулга

1. Гишүүнчлэл

- 1.1. Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт
- 1.2. Байнгын бус гишүүнээр элсэх үйл явц
- 1.3. Байнгын бус гишүүний гэрээ байгуулах

2. Бэлтгэл ажил

- 2.1. Програмын хангамж суулгуулах
- 2.2. Хүний нөөцийг сургах, бэлтгэх
- 2.3. Шаардлагатай бичиг баримтыг боловсруулах, бэлтгэх

3. Гишүүдийн бүртгэл

- 3.1. Биржийн арилжаанд оролцох гишүүдийн сан бүрдүүлэх

4. Арилжаа

- 4.1. Гишүүдээс захиалга хүлээн авах
- 4.2. Арилжаанд захиалга оруулах
- 4.3. Хэлцэл биелэх, гэрээ байгуулах
- 4.4. Бараа хүлээлцэх
- 4.5. Төлбөр тооцоо хийх

5. Хавсралт

#01

Гишүүнчлэл Биржийн байнгын бус гишүүнээр элсэх

Биржийн байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн эсвэл хэсэгчлэн хангасан хэн боловч байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргаж болох бөгөөд гишүүнээр элсэхэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх явцдаа

шалгуур үзүүлэлтүүдийг хангах боломжтой.

Биржийн байнгын бус гишүүнээр элсэх үйл явцыг схемчлэн харуулбал дараах хэлбэртэй байна.



График 4. Байнгын бус гишүүнээр элсэх процесс



Хөдөө аж ахуйн биржийн гишүүнээр элсэхтэй холбогдсон харилцааг “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”, “Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт”-ээр зохицуулсан байдаг.

1. Хөдөө аж ахуйн биржид хандах

Хэрэв танай хоршоо биржийн байнгын бус гишүүнээр элсэх эсэх талаар хэлэлцэж байгаа бол биржийн байнгын бус гишүүн болох нь ямар давуу болон

1. Биржийн арилжаанд шууд оролцох;
2. Гишүүдийнхээ бараа, түүхий эдийг нэгтгэх, анхан шатны тордолт хийх;
3. Эрсдэлгүй төлбөр тооцоо хийгдэх баталгааг гишүүдэд өгөх;

сул талтайг сайтар судлахыг зөвлөж байна.

4. Бусад.

Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус гишүүнээр элссэний давуу талуудаас дурдвал,



Хэрэв та биржийн байнгын бус гишүүнээр элсэхээр эсвэл биржийн гишүүд болон биржийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж буй тухай мэдээлэл авах бол Хөдөө аж ахуйн биржийн Гишүүнчлэлийн албанд хандаарай.

2. Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтийг хангаж буй түвшинг тогтоох

“Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу биржийн байнгын бус гишүүнээр элсэхийг хүсч буй хоршоо нь дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

1. Монгол улсын хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаагаа явуулж буй хоршоо эсвэл дундын хоршоо байх;
2. Үйл ажиллагаа явуулж буй тухайн сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх.

Байнгын бус гишүүн нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай ажлын байртай байх бөгөөд гишүүдийг хүлээн авч үйлчлэх танхимыг тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байна.

Түүнчлэн биржийн арилжаанд шууд оролцох учир захиалга хүлээн авах, биржийн арилжаанд тэдгээрийг оруулах ажлыг гүйцэтгэх ажилтан болон бараа, түүхий эдийг чанар, стандартын дагуу хүлээж авах ажилтантай байх шаардлагатай.

Бараа, түүхий эд хадгалах агуулахын хувьд өөрийн агуулахыг биржээр итгэмжлүүлсэн байх эсвэл аль нэг итгэмжлэгдсэн агуулахтай гэрээ хийж, ажиллах боломжтой.

Техник хангамжийн хувьд 512KB-аас дээш хурдтай интернет холболт болон гишүүдэд мэдээлэл хүргэх дэлгэц, хэвлэх төхөөрөмжтэй байх шаардлагатай. Арилжаанд оролцоход ашиглах компьютер нь дараах шалгуурыг хангасан байвал зохино.

№	Нэр	Үзүүлэлт
1	Процессор (CPU)	Intel core i5, 3.0GHz ба түүнээс дээш
2	Нөөцлөх санах ой (Cache)	2MB ба түүнээс дээш
3	Түр санах ой (RAM)	4GB ба түүнээс дээш
4	Хатуу диск (HARD DISK)	500GB ба түүнээс дээш
5	Үйлдлийн систем (OS)	Windows 7 буюу түүнээс дээш
6	Нэмэлт график карт	2 буюу түүнээс дээш дэлгэц холбоход ашиглах

Хүснэгт 1. Компьютерийн техникийн шаардлага

Биржээр зөвхөн итгэмжлэгдсэн агуулахад байршуулсан бараа, түүхий эдийг арилждаг тул байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргагч нь өөрийн агуулахыг биржээр итгэмжлүүлнэ.

Өөрийн агуулахгүй тохиолдолд аль нэг итгэмжлэгдсэн агуулахтай гэрээ хийж, хамтран ажиллаж болно.



Агуулахын итгэмжлэлтэй холбогдсон харилцааг “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”, бараа, түүхий эдийн агуулахад тавигдах шалгуур үзүүлэлтүүдээр зохицуулсан байдаг.

Танай хоршооны хувьд байнгын бус гишүүний шалгуурыг ямар хэмжээнд

хангаж байгааг дараах үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлж болно.

Үндсэн шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
Анхан шатны хоршоо эсвэл дундын хоршоо байх	Тийм	Үгүй
Сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх	Тийм	Үгүй
Бусад шалгуур үзүүлэлт		
Арилжаа, хяналтын ажилтантай байх	Тийм	Үгүй
Бараа, агуулах хариуцсан ажилтантай байх	Тийм	Үгүй
Тусгайлан тохижуулсан ажлын байртай байх	Тийм	Үгүй
Шаардлагад нийцсэн компьютер, тоног төхөөрөмжтэй байх	Тийм	Үгүй
Интернет холболттой эсэх	Тийм	Үгүй
Өөрийн эсвэл гэрээт итгэмжлэгдсэн агуулахтай эсэх	Тийм	Үгүй

Зураг 1. Танай хоршоо байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтийг хэдэн хувьтай хангаж байна вэ?

3. Байнгын гишүүний шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангах

Өмнөх шатанд байнгын бус гишүүнд тавигдаж буй шалгуур үзүүлэлтийг хэдэн хувьтай хангаж байгааг нэгэнт тодорхойлсон тул энэ шатанд шаардлагад нийцэхгүй байгаа үзүүлэлтүүдийг байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, интернет холболтын хувьд шаардлага хангахгүй байсан гэж үзвэл интернетийн

үйлчилгээ үзүүлэгч компанитай холбогдон шаардлагад нийцсэн интернет холболттой болох шаардлагатай. Эсвэл өөрийн агуулахыг итгэмжлүүлээгүй байх тохиолдолд биржид хандан өөрийн агуулахыг итгэмжлүүлэх гэх мэт арга хэмжээг энэ шатанд авч хэрэгжүүлнэ.



Биржийн байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй ямар ч үзүүлэлтийг энэ шатанд засаж сайжруулах, бүрэн нийцүүлэх боломжтой.

4. Биржийн зөвлөмжийн дагуу бичиг баримт бүрдүүлэх

Байнгын бус гишүүнээр элсэхээр хүсэлт гаргагчдын хувьд биржийн ажилтны тусламжтайгаар бичиг баримт бүрдүүлэх

нь цаг зав хэмнэх, хурдан шуурхай байх, зөв бүрдүүлж байгаа эсэхээ хянах зэрэг давуу талтай учраас бичиг баримтыг

биржийн ажилтны зөвлөмжийн дагуу бүрдүүлэхийг зөвлөж байна.

Байнгын бус гишүүнээр элсэхээр хүсэлт гаргаж буй этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

№	Нэр	Тайлбар
1	Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл	Биржийн маягтаар, хавсралт-1
2	Гишүүнчлэлийн анкет	Биржийн маягтаар, хавсралт-2
3	Хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	-
4	Хоршооны дүрмийн хуулбар	-
5	Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөө	Биржийн маягтаар
6	Эрх бүхий албан тушаалтан, "Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт"-ийн 2.2.1 болон 2.2.2-т ажилтнуудын анкет	Биржийн маягтаар, хавсралт-3
7	"Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт"-ийн 2.2.1 болон 2.2.2-т ажилтнууд хоршооны ажилтан болохыг нотлох тодорхойлолт	Хоршооны албан бичгээр
8	"Байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлт"-ийн 2.2.3 болон 2.2.6-д заасныг нотлох гэрэл зураг	-
9	Компьютер, техник тоног төхөөрөмж болон интернет холболт техникийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт	-
10	Аливаа санхүүгийн бичиг баримтад тухайн хоршоог төлөөлөх этгээдийн гарын үсгийн баталгаа	Биржийн маягтаар, хавсралт-4
11	Үйл ажиллагаа явуулж буй сумын малчин өрхөд үйлчилгээ үзүүлэхээр байгуулсан гэрээний хуулбар, жагсаалтын хамт	-

Хүснэгт 2. Байнгын бус гишүүнээр элсэхэд бүрдүүлэх бичиг баримт

5. Биржээс ажлын байрны шалгалт хийх

Байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргагч этгээдийн бүрдүүлсэн бичиг баримтын үнэн зөвийг нотлох, байнгын гишүүний ажлын байртай танилцах зорилгоор биржийн холбогдох албанаас

ажлын байрны шалгалт хийж болно. Энэ тохиолдолд биржээс урьдчилан мэдэгдэж, тухайн шалгалтын явцад шалгах зүйлсийн жагсаалтыг хоршоонд хүргүүлсэн байна.

6. Биржээс гэрээ байгуулах тухай мэдэгдэх

Байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргагчийн бүрдүүлсэн бичиг баримтад тулгуурлан биржийн Гишүүнчлэлийн албанаас тухайн хоршоог биржийн гишүүнээр элсүүлэх эсэх дүгнэлтийг гаргаж, биржийн Гүйцэтгэх удирдлагад

танилцуулна. Гүйцэтгэх удирдлага дүгнэлтэд үндэслэн тухайн хоршоотой гэрээ байгуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд биржээс тэр даруй мэдэгддэг.

7. Байнгын бус гишүүний гэрээ байгуулах

Байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй хоршоог төлөөлөх эрх бүхий этгээд бирж дээр биеэр ирж “Байнгын бус гишүүний гэрээ” байгуулна. Гэрээний

хүчинтэй хугацаанд байнгын бус гишүүн дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:

Эрх

- Биржийн арилжаанд шууд оролцох
- Биржээс байнгын бус гишүүдэд зориулан явуулж буй сургалт, арга хэмжээнд хамрагдах;
- Арилжаанд оролцоход шаардлагатай програм хангамж суулгуулах;
- Биржид санал хүсэлт гаргах, шаардлагатай асуудлаар харилцан зөвшилцөх;
- Бусад.

Үүрэг

- Биржийн байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажиллах;
- Биржээр арилжсан бараа, түүхий эдийн чанар, стандартыг хариуцах, анхан шатны тордолт хийсэн байх;
- Хоршооны оруулсан аливаа захиалгын үнэн зөв байдлыг хангаж ажиллах;
- Холбогдох шимтгэл, хураамж, төлбөр, үйлчилгээний хөлс зэргийг хугацаанд нь төлөх;
- Гишүүдэд биржийн арилжаатай холбоотой эрсдэл, хүлээж болзошгүй алдагдлын талаарх тайлбарыг өгөх, анхааруулах;
- Бусад.

#02

Бэлтгэл ажил

Арилжаанд оролцоход шаардлагатай програм хангамж, хүний нөөц, бичиг баримтыг бэлтгэх

.....

1. Арилжаанд оролцоход шаардлагатай програм хангамжийг суулгуулах

Арилжаанд оролцоход шаардлагатай програм хангамжууд болох агуулахын бүртгэлийн програм, арилжааны програм зэрэг шаардлагатай програм

хангамжуудыг суулгуулахын тулд тухайн байнгын бус гишүүн биржийн Гишүүнчлэлийн албанд албан хүсэлт гаргана.

А. Агуулахын бүртгэлийн програм

Агуулахын бүртгэлийн програм нь биржээс эрх авсан итгэмжлэгдсэн агуулахад ашиглагдах зориулалттай бөгөөд агуулахад хадгалагдаж байгаа барааны хөдөлгөөнийг бүртгэхээс гадна барааны үлдэгдлийг агуулахад бараа хадгалуулсан хоршооны гишүүд болон бараа, түүхий эдийн төрөл, ангилал тус бүрээр ялгаж харах боломжтой.

Өөрийн агуулахыг итгэмжлүүлсэн тохиолдолд энэхүү програмыг суулгаж, бараа, агуулах хариуцсан ажилтан уг

програмыг ашиглан дараах үйлдлийг хийх боломжтой. Үүнд:

- Бараа хадгалуулсан хоршооны гишүүний бүртгэлийг харах;
- Агуулахад хүлээн авсан, агуулахаас ачуулсан барааны мэдээлэл оруулах;
- Барааны хөдөлгөөний жагсаалт харах;
- Барааны үлдэгдлийн хэмжээг харах;
- Бусад.

Б. Арилжааны програм

Арилжааны програмыг суулгуулснаар арилжаанд өөрийн ажлын байрнаас оролцох боломж бүрдэнэ. Арилжаанд оролцохдоо “Агуулахын бүртгэлийн програм”-д оруулсан мэдээллүүдийг ашиглана. Жишээлбэл, Агуулахын бүртгэлийн програм дээр шивсэн:

- Барааны код
- Барааны нэр

“Агуулахын бүртгэлийн програм”-д оруулсан барааны хэмжээгээр арилжаанд орно. Хэрэв танай хоршоо агуулахдаа 200 кг ноолууртай гэж програмд оруулсан бол арилжааны үеэр хамгийн дээд тал нь 200 кг ноолуур зарах захиалга л оруулж болно гэсэн үг.



Дээрх програмуудыг биржээс эхний удаад үнэ төлбөргүй суулгаж өгөх бөгөөд програм суулгуулах албан хүсэлтээ Гишүүнчлэлийн албанд бичгээр гаргана.

Байнгын бус гишүүний албан хүсэлтэд үндэслэн биржээс холбогдох програм

Дээрх хоёр програм хангамж дээр өөр, өөр үйлдлүүдийг гүйцэтгэх бөгөөд бараа агуулахад хүлээн авах, бүртгэх үйлдэл нь “Арилжааны програм” ашиглан арилжаанд оролцоход шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлж буй хэрэг юм.

Арилжааны програмыг арилжаа хариуцсан ажилтан ашиглах бөгөөд дараах үйлдлийг хийх боломжтой. Үүнд:

- Бараа түүхий эдийг арилжаанд оруулах;
- Захиалгын түүх харах;
- Хэлцлийн жагсаалт харах;
- Бусад.

суулган, шаардлагатай заавар зөвлөгөө, гарын авлагаар хангана.

2. Хүний нөөцийг сургах, бэлтгэх

Хөдөө аж ахуйн биржээс гишүүддээ зориулан анхан шатны болон гүнзгийрүүлсэн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулдаг бөгөөд эдгээр сургалтуудыг танхимын болон онлайн хэлбэрээр гишүүдэд хүргэдэг. Байнгын бус гишүүн хоршоодын хувьд сургалтын

хөтөлбөртэй биржийн Гишүүнчлэлийн албаар дамжуулан танилцаж, өөрийн хоршоонд тохирсон хөтөлбөрийг сонгон хамрагдаж болно. Байнгын бус гишүүний бүтцэд байх ажилтнууд дараах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллана.

	Тавигдах шаардлага	Гүйцэтгэх үндсэн үүрэг
Арилжаа, хяналтын ажилтан	<ul style="list-style-type: none">▪ Арилжааны програм ашиглах чадвартай байх▪ Ажлын дадлага туршлагатай байх, дотоод хяналтын ажлыг гүйцэтгэх мэдлэгтэй байх	<ul style="list-style-type: none">▪ Арилжааны програмд захиалгыг шинээр болон засварлан шивж оруулах, цуцлах▪ Хэлцлийн жагсаалтыг дагуу гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах▪ Арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт авах▪ Хоршооны мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт биржид мэдэгдэх▪ Хоршооны дотоод хяналтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх▪ Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх▪ Бусад

<p>Бараа, агуулах хариуцсан ажилтан</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол улсын болон биржийн стандартыг мэдсэн байх ▪ Бараа, түүхий эдийн чанар, стандарт, ангиллыг таних мэдлэг, туршлагатай байх 	<ul style="list-style-type: none"> ▪ Биржээр арилжих бараа, түүхий эдийг биржийн барааны тодорхойлолтод нийцүүлэх ▪ Бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахад шалгаж хүлээн авах, хүлээлгэн өгөх ▪ Бараа, түүхий эдийн тээвэрлэлт, хүргэлттэй холбоотой ажлыг хариуцах ▪ Гишүүдээс захиалга хүлээн авах ▪ Бусад
--	---	--

Хүснэгт 3. Байнгын бус гишүүний ажилтнуудын гүйцэтгэх үүрэг

3. Шаардлагатай бичиг баримтыг бэлтгэх

Байнгын бус гишүүн нь биржийн арилжаанд оролцох явцдаа дараах бичиг баримтуудыг өөрийн хоршооны онцлогтоо тохируулан боловсруулж хэрэглэж хэвших хэрэгтэй. Үүнд:

- Гишүүдтэй байгуулах гэрээ – Тухайн үйл ажиллагаа явуулж буй сумын малчид, тариаланчид танай хоршоогоор дамжуулан биржийн арилжаанд орох тохиолдолд энэхүү гэрээг байгуулсан байх шаардлагатай.

Гэрээ байгуулахад тухайн гишүүний мэдээллийг үнэн зөв бөглүүлэн авахаас гадна биржийн арилжааны талаарх мэдээлэл, учирч болзошгүй эрсдэлийг сайтар ойлгуулах нь чухал.

- Захиалгын гэрээ – Хоршооны гишүүн биржийн арилжаанд оролцох тохиолдолд түүний захиалгыг бүртгэж авах шаардлагатай бөгөөд гишүүний гарын үсэг, тамгыг ашиглан баталгаажуулна. Энэ нь арилжаатай холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх баримт болох юм.

Захиалгын гэрээ байгуулахад тухайн гишүүний захиалгыг үнэн зөв бүртгэж, хоёр тал баталгаажуулсан байх шаардлагатай.

Дээр дурдсан баримтуудаас гадна дараах баримтуудыг ашиглах бөгөөд эдгээр баримтууд “Агуулахын бүртгэлийн програм”-аас хэвлэгдэн гарна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан баримт
- Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахаас ачих баримт
- Хүргэлтийн даалгаврын маягт

Энэхүү маягт болон гэрээг тогтмол ашиглаж хэвших нь байнгын бус гишүүн болон гишүүдийн хооронд аливаа асуудал, маргаан үүсэхээс сэргийлж, маргааныг шийдвэрлэх баримт болохоос гадна санхүүгийн баримт болж чадах давуу талтай юм.



Эдгээр гэрээ болон маягтуудын загварыг биржээс авч болох бөгөөд гишүүн – байнгын гишүүн хооронд ашиглах зарим маягтуудыг өөрийн хоршооны онцлогт тохируулан өөрчилж хэрэглэх боломжтой.

#03

Гишүүдийн бүртгэл Биржийн арилжаанд оролцох гишүүдийн сан бүрдүүлэх

Байнгын бус гишүүн арилжаанд оролцохын тулд тухайн сумынхаа малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлдэг байх гэсэн шалгуурыг хангасан байна. Энэ шалгуур үзүүлэлт нь тухайн хоршоо сумаа төлөөлж буйг илтгэх нэг үзүүлэлт болно. Байнгын бус гишүүнээр үйл ажиллагаа явуулах гэж буй хоршоо тухайн сумынхаа иргэдийг арилжаанд оролцоход захиалгыг нь үнэн зөв хүлээн авч, бараа, түүхий эдийг нь найдвартай агуулахад хадгалж, анхан шатны тордолт хийх зэрэгт баталгаа болгож гэрээ байгуулсан байна.

Түүнчлэн энэхүү гэрээнд мөн анхан шатны тордол хийсэн болон хоршооны үйл ажиллагаатай холбогдон гарах зардал зэргийг тооцсон шимтгэл эсвэл хураамж авах бол тэр тухай тусгаж оруулсан байна.

Хоршооны гишүүд нь хувь хүн /малчин, тариаланч г.м/ байх бөгөөд тухайн хувь хүнтэй гэрээ байгуулахад 2-р шатанд өөрийн хоршооны онцлогт тохируулан бэлтгэсэн гэрээг ашиглаж, гэрээний хувийг хадгална. Гэрээ байгуулахдаа дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- Тухайн хувь хүнд биржийн арилжааны талаарх мэдлэг олгох, учирч болзошгүй эрсдэлүүдийг таниулах;

- Төлбөр тооцоо хийх банкны дансны мэдээллийг үнэн зөв бөглүүлэх, нягтлан хүлээн авах;
- Гишүүд / хувь хүнд үйлчилгээ үзүүлсний төлөө авах шимтгэл, хураамжийн хэмжээг тохиролцох;
- Гэрээний хугацааг тогтох;
- Гишүүд / хувь хүн болон хоршооны эрх, үүргийг сайтар ойлгуулах.

Байнгын бус гишүүдийн хувьд гишүүдтэйгээ гэрээ байгуулах үйл явц мөн чухал бөгөөд гишүүдийн тоо, тэдний нийлүүлэх бараа, түүхий эдийн хэмжээ өндөр байх тусам байнгын бус гишүүний орлого нэмэгдэж, хоршооны гишүүдэд ногдох зардал буурах давуу тал гарч болно. Тиймээс энэ шатанд хэрхэн гишүүдээ нэмэгдүүлэх, гишүүдийн нийлүүлж буй бараа, түүхий эдийн хэмжээ, чанар стандартыг хэрхэн дээшлүүлэх тухай бодлого хэрэгжүүлэх, гишүүд биржийн арилжаанд орох сонирхол төрүүлэхүйцээр мэдээ, мэдээлэл түгээх хэрэгтэй.

Тухайн байнгын бус гишүүн хоршооны гишүүдийн хүрээ өргөн байх тусам арилжааны дүн өсөх, түүнийг дагаад гишүүдэд ногдох зардал буурах нэг хүчин зүйл болох тул энэ чиглэлээр тодорхой үр дүнтэй ажлууд хэрэгжүүлэх нь чухал юм.

#04

Арилжаа

Биржийн арилжаанд оролцох

Байнгын бус гишүүн нь зөвхөн өөрийн хоршооны нэрээр биржийн арилжаанд захиалга оруулах боломжтой.

Биржтэй байнгын бус гишүүний гэрээ байгуулсан хоршоо нь биржийн арилжаанд оролцохын тулд арилжааны данстай байх шаардлагатай бөгөөд энэхүү данс нь тухайн хоршоог биржийн өмнө төлөөлөх, захиалга оруулахад ашиглагдах данс байна.

Арилжааны дансыг биржийн аль нэг байнгын гишүүн брокерын компанид очиж нээлгэх бөгөөд байнгын гишүүдийн жагсаалтыг биржээс авч болно.

Биржийн ихэнх бараа, түүхий эдийн арилжаа ажлын өдөр бүр 11.00 – 12.00 цагийн хооронд явагддаг бөгөөд хоршоод өөрийн ажлын байрнаас онлайнаар арилжаанд шууд оролцох боломжтой.

Арилжаанд оролцохын тулд итгэмжлэгдсэн агуулахад бараатай байх бөгөөд арилжааны үеэр захиалга оруулж, өөрчлөх, цуцлах гэх зөвшөөрөгдсөн үйлдлийг хийж гүйцэтгэнэ.

Арилжааны процесс ихэнх арилжааны хувьд дараах хэлбэрээр явагдана.




График 5. Арилжааны процесс

1. Гишүүдийн захиалгыг хүлээн авах

Хоршоо гишүүдийнхээ захиалгыг хүлээн авч, хоёр тал гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсны дараагаар захиалгын гэрээний нэг хувийг гишүүнд өгч, өөрт нэг хувийг хадгалан, биржид мөн нэг хувийг ирүүлнэ.



Байнгын бус гишүүн арилжааны програмд захиалга оруулан, арилжаанд оролцох тохиолдолд баталгаат дэнчин урьдчилан байршуулсан байх шаардлагатайг анхаарна уу.

Хоршоо өөрийн нэрээр арилжиж буй бараа, түүхий эдийн чанар, стандартын баталгаа болгож баталгаат дэнчин байршуулдаг. Биржээр дамжуулан арилжсан бараа, түүхий эдийн хүргэлт

Захиалгын гэрээнд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

- Гишүүний товч мэдээлэл
- Хоршооны арилжааны дансны дугаар
- Барааны нэр, хэмжээ
- Захиалга биелэх нөхцөл
- Бусад.

хийгдэж, худалдан авагч бараагаа авсан тохиолдолд энэхүү дэнчинг тухайн хоршооны данс руу буцаан шилжүүлнэ.



Дэнчинтэй холбоотой асуудлаар биржийн Клиринг, төлбөр тооцооны албанд хандаж болно.

Гишүүдийн захиалгыг хүлээн авахад анхаарах зүйлс:

Байнгын бус гишүүний бараа, агуулах хариуцсан ажилтан гишүүдийнхээ бараа, түүхий эдийн чанар биржийн стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлно.

Биржийн стандартад нийцэхгүй байх тохиолдолд бараа, агуулах хариуцсан ажилтан гишүүдийнхээ бараа, түүхий эдийг агуулахдаа хүлээн авч, анхан шатны тордолт хийх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Биржээр арилжих бараа, түүхий эдийг биржийн стандартад нийцүүлсэн

тохиолдолд л биржээр арилжих боломжтой тул бараа, агуулах хариуцсан ажилтан энэ стандартыг сайтар судалж мэдсэн байхаас гадна хоршооны гишүүд хэрхэн анхан шатны тордолт хийх тухай ярилцаж, үйл ажиллагааг тохирсон байх нь зүйтэй.

Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан дараах нэр төрлийн бараа, түүхий эдийг одоогийн байдлаар арилжих боломжтой.




График 5. Биржээр арилжих бараа, түүхий эд

2. Арилжаанд захиалга оруулах

Байнгын бус гишүүн арилжаанд онлайнгаар буюу өөрийн ажлын байрнаас арилжааны програмд холбогдож захиалга оруулах байдлаа арилжаанд оролцож болно.

Биржийн арилжааны дийлэнх нь ажлын өдрүүдэд 11:00-12:00 цагийн хооронд явагдах бөгөөд энэ үеэр ажлын байрандаа ирж арилжааны програмаа ашиглан захиалгуудаа оруулна.

Арилжааны үеэр биржээс шаардлагатай тодруулга авах бол арилжааны програм ашиглан "Арилжаа хөтлөгч"-д хандаж тусламж авах боломжтой.

Арилжаа нь арилжааны өмнөх үе, арилжааны үе, хаалтын үе гэсэн 3 үетэй ба цагийн хуваарийг "Биржийн гэрээний стандарт"-д заасан байдаг.

- Арилжааны өмнөх үед дуудлага худалдааны аргачлалаар зөвхөн нэг үнэ тогтох бөгөөд зах зээлийн болон нөхцөлт захиалгуудыг зөвшөөрнө.



Арилжааны үеэр оруулах боломжтой захиалгын төрөл болон арилжаа хэрхэн явагдахтай холбогдсон харилцааг "Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам" болон "Арилжааны журам"-аар нарийвчлан зохицуулсан байдаг.

- Арилжааны үед үргэлжилсэн дуудлага худалдааны аргачлалаар 5 минут тутамд үнэ тогтох ба бүх төрлийн захиалгуудыг зөвшөөрнө.
- Арилжааны хаалтын үед дуудлага худалдааны аргачлалаар зөвхөн нэг үнэ тогтох бөгөөд зах зээлийн болон нөхцөлт захиалгуудыг зөвшөөрнө.

Зах зээлийн захиалга гэж бирж дээр тогтсон үнэ ямар ч бай тэр үнээр худалдах санал бүхий захиалгыг хэлэх бол нөхцөлт захиалга нь өөрийн оруулсан буюу түүнээс дээш үнээр бараа, түүхий эдийн худалдахаар өгч буй саналыг хэлдэг.

Дээрх захиалгуудыг гадна бусад нэмэлт өгөгдөл бүхий захиалгуудыг арилжаанд оруулах боломжтой байдаг.

3. Хэлцэл биелэх

Програмд оруулсан захиалгууд биелснээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах хэлцлүүд хийгдэнэ. Байнгын бус гишүүнд харгалзах хэлцлийн жагсаалтыг арилжааны програмаар дамжуулан харж, хэвлэх боломжтой.

Тухайн хэлцлийн жагсаалтын дагуу бараа, түүхий эдийг худалдан авах талтай гэрээ байгуулж хэлцлийг баталгаажуулна.

Хэлцлийн жагсаалтад дараах зүйлсийг тусгасан байдаг. Үүнд:

- Хэлцлийн дугаар;
- Бараа, түүхий эд худалдан авсан этгээдийн мэдээлэл
- Ямар хэмжээтэй бараа, түүхий эд тухайн хоршоо худалдсан тухай мэдээлэл;
- Бусад.

4. Худалдах, худалдан авах гэрээ байгуулах

Биржийн арилжаа явагдаж дууссаны дараагаар тухайн хэлцэлд харгалзах худалдах, худалдан авах гэрээг байгуулна. Худалдах, худалдан авах гэрээнд дараах зүйлсийг тусгасан байдаг. Үүнд:

- Худалдагч болон худалдан авагчийн товч мэдээлэл
- Худалдах бараа, түүхий эдийн хэмжээ, үнэ гэх мэт мэдээлэл
- Хүргэлтийг хэрхэн гүйцэтгэх тухай мэдээлэл
- Гэрээг баталгаажуулсан байдал

Худалдах, худалдан авах гэрээг

худалдан авч буй талтай баталгаажуулсны дараагаар биржид ирүүлнэ. Бирж тухайн гэрээг хүлээн авсан даруйд бараа, түүхий эдээ ачуулах, худалдан авагчид хүлээлгэн өгөх тухай хоршоонд мэдэгдэнэ.

Хоршоо бараа, түүхий эдээ худалдагч талтай хүлээлцсэн тухайгаа биржид мэдэгдсэнээр биржээс хоршооны дансанд тухайн гэрээний төлбөрийг шилжүүлнэ. Худалдан авагч тал гэрээний төлбөрөө худалдах, худалдан авах гэрээ хийсэн даруйдаа биржийн дансанд урьдчилан байршуулсан байдаг.

5. Бараа, түүхий эдийг хүргэх, хүлээлцэх

Бараа, түүхий эдийн хүргэлтийг биржийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр дамжуулан гүйцэтгэж болох бөгөөд эсвэл талууд тохиролцон өөрсдийн тээврээр гүйцэтгэх боломжтой. Бараа, түүхий эдийн хүргэлттэй холбогдсон харилцааг хоршооны бараа, агуулах хариуцсан ажилтан хариуцна.

Бараа, агуулах хариуцсан ажилтан нь бараа, түүхий эдийг тоо ёсоор хүлээн авч, агуулахад хүлээн авснаас хойш чанарыг алдагдуулахгүй хадгалах, анхан шатны тордолт хийх ажлыг хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй.

Түүнчлэн бараа, түүхий эд хүлээлцэхэд бараа, агуулах хариуцсан ажилтан өөрийн биеэр байлцах шаардлагатай бөгөөд бараа, түүхий эдийн чанар, стандартыг хянаж хүлээн авч, хүлээлгэн өгнө.

Бараа хүлээлгэж өгөх, бараа хүлээн авахдаа дараах бичиг баримтуудыг хөтөлнө. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан баримт – Энэ баримтыг хоршооны гишүүн агуулахад бараа авчирч өгсөн, итгэмжлэгдсэн тээвэрлэгч агуулахад бараа хүргэж ирсэн тохиолдолд үйлдэнэ. Баримтыг 3 хувь үйлдэж, хоршоонд 2 хувь үлдэж, гишүүнд 1 хувийг өгнө.
2. Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахаас ачих баримт – Энэ баримтыг бараагаа буцаан авсан, бараагаа худалдсан, итгэмжлэгдсэн тээвэрлэгч бараа хүлээн авч, худалдан авагчид хүргэж өгөхөөр тээвэрлэсэн тохиолдолд үйлдэнэ. Баримтын 1 хувь хоршоонд үлдэж, харилцагчид 1, худалдан авагчид 1 хувийг тус тус өгнө.



Биржийн барааны стандарт, агуулах, хүргэлт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар Логистик, барааны албанд хандах боломжтой.

Хавсралт

Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус гишүүнээр элсэхэд бүрдүүлэх бичиг баримтууд

1. Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл
2. Биржийн гишүүний анкет
3. Ажилтнуудын анкет
4. Гарын үсгийн баталгааны маягт

Гишүүдээс захиалга авахтай холбогдон ашиглах бичиг баримтууд

5. Захиалгын гэрээ

Дэнчин байршуулахтай холбоотой ашиглах бичиг баримтууд

6. Дэнчин байршуулах зааварчилгаа
7. Дэнчин буцаах хүсэлтийн маягт

Бараа хүлээлцэх маягт

8. Бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан баримт
9. Бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахаас ачих баримт
10. Хүргэлтийн даалгаврын маягт

Гэрээний стандарт

11. Ноолуур
12. Тэмээний ноос
13. Хонины ноос

Хавсралт 1. Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл



“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д

Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл

Хүсэлт гаргаж буй этгээдийн мэдээлэл

Нэр: _____

Регистрийн дугаар: _____ Утасны дугаар: _____

Байнгын бус гишүүний

үйл ажиллагааны чиглэл: _____

- түүхий эд боловсруулалтын үйлдвэрлэлийн үйлчилгээний
 борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн бусад _____

Агуулах итгэмжлүүлэх эсэх (Өөрийн эсвэл гэрээт агуулахын талаарх товч мэдээллийг бичих):

Нэмэлт мэдээлэл:

Хоршооны дарга: _____
Нэр *Гарын үсэг, тамга* *Огноо*

Өргөдлийг шийдвэрлэсэн байдал (Зөвхөн бирж бөглөнө)

Зөвшөөрсөн: _____ Татгалзсан: _____

Нэмэлт мэдээлэл: _____

Гарын үсэг, тамга

Огноо

Баталгаажилт

Биржийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн эсэх: Тийм Үгүй

Байнгын бус гишүүнээр элсэх

шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн: _____
Гарын үсэг, тамга *Огноо*

Хүлээн зөвшөөрсөн бол биржийн Гишүүнчлэлийн албанд хүлээлгэн өгнө үү.

Хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд холбогдох нотолгоо, үндэслэлийг биржид ирүүлнэ.

Хавсралт 2. Байнгын гишүүний анкет



ГИШҮҮНЧЛЭЛИЙН АНКЕТ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Нэр:		
Байгуулагдсан огноо:	Регистрийн дугаар:	Ажиллах цагийн хуваарь:
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:		Орон нутгийн харьяалал:
Хаяг:		
Утас (ажил):	Утас (бусад 1):	Утас (бусад 2):
Цахим хуудас:	Цахим шуудан:	Факс:
Ажлын байр:	Түрээсийн байртай бол түрээсийн гэрээг хавсаргана уу.	
<input type="checkbox"/> Хувийн	<input type="checkbox"/> Түрээсийн	
ГИШҮҮНЧЛЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ		
Гишүүнчлэлийн төрөл: <input type="checkbox"/> БАЙНГЫН ГИШҮҮН <input type="checkbox"/> БАЙНГЫН БУС ГИШҮҮН		
Гишүүний эрхийн төрөл: <input type="checkbox"/> Арилжааны эрх <input type="checkbox"/> Зуучлалын эрх <input type="checkbox"/> Зах зээл үүсгэх эрх <input type="checkbox"/> Клирингийн эрх		
Урьд өмнө нь биржийн гишүүн байсан эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй		
Тийм гэж хариулсан биржийн гишүүнчлэл цуцлагдсан шалгааныг бичих:		
БРОКЕР БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ		
Нэр:	Албан тушаал:	
Нэр:	Албан тушаал:	
Нэр:	Албан тушаал:	
Нэр:	Албан тушаал:	
УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭЭЛЭЛ		
Нэр:	Албан тушаал:	
Нэр:	Албан тушаал:	
ТӨЛБӨР ТООЦООНД АШИГЛАХ ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Дансны дугаар 1:		
Банк 1:	Данс эзэмшигчийн нэр 1:	
Дансны дугаар 2:		
Банк 2:	Данс эзэмшигчийн нэр 2:	
БУСАД		
Гишүүнээр элссэн мэргэжлийн холбоодын нэрийг бичнэ үү.		
БАТАЛГААЖУУЛАЛТ		
Энэхүү анкетад бичигдсэн бүх мэдээлэл үнэн зөв болохыг баталж байна.		
Овог, нэр:	Албан тушаал:	
Гарын үсэг, тамга:	Огноо:	

Хавсралт 3. Байнгын бус гишүүний ажилтнуудын анкет



Эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын анкет

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Овог:	Нэр:	Зурга 3x4
Регистрийн дугаар:	Төгссөн огноо:	
Хүйс: <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм		
Утас (ажил):	Утас (хувийн):	
Утас (бусад 1):	Цахим шуудан:	
Хаяг:		
БОЛОВСРОЛ (ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)		
Сургуулийн нэр (1):	Сургуулийн нэр (2):	
Эзэмшсэн мэргэжил:	Эзэмшсэн мэргэжил:	
Элссэн огноо:	Элссэн огноо:	
Төгссөн огноо:	Төгссөн огноо:	
Диплом, гэрчилгээний дугаар:	Диплом, гэрчилгээний дугаар:	
Сургуулийн нэр (3):	Сургуулийн нэр (4):	
Эзэмшсэн мэргэжил:	Эзэмшсэн мэргэжил:	
Элссэн огноо:	Элссэн огноо:	
Төгссөн огноо:	Төгссөн огноо:	
Диплом, гэрчилгээний дугаар:	Диплом, гэрчилгээний дугаар:	
АЖЛЫН ТУРШЛАГА		
Байгууллагын нэр (1):	Байгууллагын нэр (2):	
Албан тушаал:	Албан тушаал:	
Ажилд орсон огноо:	Ажилд орсон огноо:	
Ажлаас гарсан огноо:	Ажлаас гарсан огноо:	
Байгууллагын нэр (3):	Байгууллагын нэр (4):	
Албан тушаал:	Албан тушаал:	
Ажилд орсон огноо:	Ажилд орсон огноо:	
Ажлаас гарсан огноо:	Ажлаас гарсан огноо:	
БУСАД		
Биржийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэг мэргэжлийн сургалтад хамрагдсан бол жагсаан бичнэ үү.		
БАТАЛГААЖУУЛАЛТ		
Энэхүү анкетэд бичигдсэн бүх мэдээлэл үнэн зөв болохыг баталж байна.		
Овог, нэр:	Албан тушаал:	
Гарын үсэг, тамга:	Огноо:	

Хавсралт 4. Гарын үсгийн баталгааны маягт

**"ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН ГИШҮҮНИЙ
САНХҮҮГИЙН БАРИМТАД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН
ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ**

оны сарын өдөр

Хуулийн этгээдийн нэр	
Арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхэд ашиглагдах данс	
Дансны дугаар (1)	
Данс эзэмшигчийн нэр	
Банкны нэр	
Дансны дугаар (2)	
Данс эзэмшигчийн нэр	
Банкны нэр	

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн гишүүн -ийг төлөөлж
..... албан тушаалтай овогтой
.....-д итгэмжлэл олгон, арилжааны төлбөр тооцоотой холбогдсон үйл
ажиллагаагааг хариуцан гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулж байна.

№	Данс эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Баталгаат гарын үсэг
1			
2			
	Төлөөлсөн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Баталгаат гарын үсэг
1			
2			

Эрх бүхий албан тушаалтны баталгаажуулалт

Овог, нэр: _____ Албан тушаал: _____

Гарын үсэг, тамга: _____ Огноо: _____

Хавсралт 5. Захиалгын гэрээ

ЗАХИАЛГЫН ГЭРЭЭ	“.....” ХХК	УТАС:
Дугаар ____		

ЗАХИАЛГЫН ТӨРӨЛ	<input type="checkbox"/> Авах	<input type="checkbox"/> Зарах
Ноолуур	Өнгө	Боловсруулалт
		Чанар
Хонины ноос	Өнгө	Боловсруулалт
		Чанар
Бодын хөөвөр	Өнгө	Боловсруулалт
		Ямар мал
Тэмээний ноос	Өнгө	Боловсруулалт
		Чанар
Хүнсний буудай	Хатуулаг	Зэрэг
Тосны ургамал	Өнгө	
Завод ноос	Өнгө	Ямар мал
Мал	Хүйс	Ямар мал
		Нас
НЭГЖИЙН ҮНЭ		
ХЭМЖЭЭ (БОГЦ)		
НЭМЭЛТ НӨХЦӨЛ	<input type="checkbox"/> Биелүүл эсвэл цуцал	<input type="checkbox"/> Ядаж заасныг /___/
ХҮЛЭЭЛЦЭХ ЦЭГ		
ШИМТГЭЛ		

ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ	
Овог, нэр:	Регистрийн дугаар:
Арилжааны данс:	Утас:
Төлбөр хийх хэлбэр:	
<input type="checkbox"/> Бэлнээр	<input type="checkbox"/> Дансаар
Төлбөр хийх банк:	Төлбөр хийх данс:
Данс эзэмшигчийн нэр:	
ЗАХИАЛГЫН ӨӨРЧЛӨЛТ	
1	
2	
3	
4	
5	
6	
7	
8	
9	
10	

Огноо:	Захиалга хүлээн авсан:	Захиалга өгсөн:
--------------	------------------------------	-----------------------

Хавсралт 6. Дэнчин байршуулах зааварчилгаа

БИРЖИЙН ДЭНЧИНГИЙН ДАНС

	Банкны нэр	Дансны дугаар
Дэнчингийн данс	ХААН банк	5131 00 5005
	Төрийн банк	1060 0088 8884

ДЭНЧИН БАЙРШУУЛАХ ГҮЙЛГЭЭНИЙ УТГА

1. Арилжаанд оролцогчийн арилжааны дансны дугаар (биржээс олгосон 10 оронтой дугаар)
2. Арилжаанд оролцогчийн регистрийн дугаар (хувь хүн бол өөрийн, компани бол татвар төлөгчийн дугаар)
3. Дэнчингийн төрөл (баталгаат, анхдагч эсвэл хүргэлтийн)

Жишээ нь:

0001000001 УС69010101 БАТАЛГААТ ДЭНЧИН

Хавсралт 7. Дэнчин буцаах хүсэлтийн маягт



ДЭНЧИНГИЙН МӨНГӨ БУЦААХ ХҮСЭЛТ

Огноо:

Хэнд: ХААБ -ТӨХХК Клиринг,төлбөр тооцооны алба	Арилжаанд оролцогчийн дансны дугаар:	Дэнчин буцаах хүсэлт гаргасан харилцагчийн дансны дугаар:
Дэнчингийн дүн:	Дэнчингийн дүн, бичгээр:	
Дэнчин хүлээн авах данс	Банк:	Дансны дугаар: Данс эзэмшигчийн нэр:
ХҮСЭЛТ ГАРГАСАН БРОКЕРЫН КОМПАНИЙ ЗАХИРАЛ :		
ТАМГА		

Жич: Харилцагчийн хүсэлтийг хавсаргах шаардлагатайг анхаарна уу.

Хавсралт 8. Бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан баримт



Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг
итгэмжлэгдсэн агуулахад хүлээн авсан баримт

20__ он __ сар __ өдөр

БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Код: _____

Бүлэг: _____

Бараа: _____

Хэмжээ: _____ кг

ХАРИЛЦАГЧ

Нэр: _____

Регистрийн дугаар: _____

Харилцагчийн данс: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

АГУУЛАХ

Аймаг: _____

Сум: _____

Агуулахын нэр: _____

Утас: _____

Хүлээлцсэн мэргэжилтний овог, нэр, код:

Гарын үсэг: _____

Брокерийн компанийн нэр:

Барааны брокерын овог, нэр:

Гарын үсэг: _____

Хавсралт 9. Бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн агуулахаас ачих баримт



Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийг
итгэмжлэгдсэн агуулахаас ачих баримт

БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

20__ он __ сар __ өдөр

Код: _____

Бүлэг: _____

Бараа: _____

Хэмжээ: _____ кг

АГУУЛАХ

Аймаг: _____

Сум: _____

Харилцагчийн РД: _____

Агуулахын нэр: _____

Утас: _____

Хүлээлцсэн мэргэжилтний овог, нэр:

Гарын үсэг: _____

ТЭЭВЭРЛЭГЧ

Байгууллагын нэр: _____

Жолоочийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Жолооны үнэмлэхний дугаар: _____

Тээврийн хэрэгслийн улсын дугаар: _____

Гарын үсэг: _____

Хавсралт 10. Хүргэлтийн даалгаврын маягт



Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн
хүргэлтийн даалгавар

20__ он __ сар __ өдөр

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ

Код: _____

Бүлэг: _____

Бараа: _____

Хэмжээ _____ кг

Хөдөө аж ахуйн биржийн ажилтны нэр, гарын үсэг: _____

АЧИХ АГУУЛАХ

Аймаг/хот, сум/дүүрэг:

Агуулахын нэр: _____

Код: _____

Утас: _____

Хүлээлцсэн мэргэжилтний овог, нэр:

Гарын үсэг: _____

БУУЛГАХ АГУУЛАХ

Аймаг/хот, сум/дүүрэг:

Агуулахын нэр: _____

Код: _____

Утас: _____

Хүлээлцсэн мэргэжилтний овог, нэр:

Гарын үсэг: _____

НООЛУУР

Гэрээний төрөл	Спот
Гэрээний код	001100-001320
Гэрээний хэмжээ	1 богц=100 кг
Гэрээний үнийн хэлбэлзэл (хамгийн бага өөрчлөлт)	500 төгрөг
Гэрээ баталгаажуулах өдөр	T+1 (дараагийн арилжааны үе хүртэл)
Үнийн өөрчлөлтийн хязгаар	10 % (өдрийн)
Арилжааны цаг	11:00-12:00 (+8 бүс)
Гэрээний сүүлийн өдөр	Арилжааны өдөр
Гэрээ хаагдах сар	1-12 сар
Төлбөр тооцооны нөхцөл	T +1 (бараа ачигдсан өдрөөс тооцно)
Захиалгын хязгаар (өдрийн)	1000 гэрээ
Хүргэлтийн нөхцөл	T+10 (хүртэл)
Хүргэлтийн цэг	Итгэмжлэгдсэн агуулах
Үнэ тогтох аргачлал	“Арилжааны журам” 5.3-р хэсэг
Дэнчин	“Клиринг, төлбөр тооцооны журам” 2-р бүлэг
Барааны шаардлага	“Тэмээний ноосны тодорхойлолт” 3-р бүлэг

ТЭМЭЭНИЙ НООС

Гэрээний төрөл	Спот
Гэрээний код	004101-004223
Гэрээний хэмжээ	1 богц=100 кг
Гэрээний үнийн хэлбэлзэл (хамгийн бага өөрчлөлт)	500 төгрөг
Гэрээ баталгаажуулах өдөр	T+1 (дараагийн арилжааны үе хүртэл)
Үнийн өөрчлөлтийн хязгаар	10 % (өдрийн)
Арилжааны цаг	11:00-12:00 (+8 бүс)
Гэрээний сүүлийн өдөр	Арилжааны өдөр
Гэрээ хаагдах сар	1-12 сар
Төлбөр тооцооны нөхцөл	T +1 (бараа ачигдсан өдрөөс тооцно)
Захиалгын хязгаар (өдрийн)	1000 гэрээ
Хүргэлтийн нөхцөл	T+10 (хүртэл)
Хүргэлтийн цэг	Итгэмжлэгдсэн агуулах
Үнэ тогтох аргачлал	“Арилжааны журам” 5.3-р хэсэг
Дэнчин	“Клиринг, төлбөр тооцооны журам” 2-р бүлэг
Барааны шаардлага	“Тэмээний ноосны тодорхойлолт” 3-р бүлэг

ХОНИНЫ НООС

Гэрээний төрөл	Спот
Гэрээний код	002003-002222
Гэрээний хэмжээ	1 богц=100 кг
Гэрээний үнийн хэлбэлзэл (хамгийн бага өөрчлөлт)	500 төгрөг
Гэрээ баталгаажуулах өдөр	T+1 (дараагийн арилжааны үе хүртэл)
Үнийн өөрчлөлтийн хязгаар	10 % (өдрийн)
Арилжааны цаг	11:00-12:00 (+8 бүс)
Гэрээний сүүлийн өдөр	Арилжааны өдөр
Гэрээ хаагдах сар	1-12 сар
Төлбөр тооцооны нөхцөл	T +1 (бараа ачигдсан өдрөөс тооцно)
Захиалгын хязгаар (өдрийн)	1000 гэрээ
Хүргэлтийн нөхцөл	T+10 (хүртэл)
Хүргэлтийн цэг	Итгэмжлэгдсэн агуулах
Үнэ тогтох аргачлал	“Арилжааны журам” 5.3-р хэсэг
Дэнчин	“Клиринг, төлбөр тооцооны журам” 2-р бүлэг
Барааны шаардлага	“Тэмээний ноосны тодорхойлолт” 3-р бүлэг